ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2020 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/11 Арвайхээр

Сувилахуй, эх барихуйн чиглэлээр авах
зарим арга хэмжээний тухай

Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Сувилахуй, эх барихуйн чиглэлээр авах арга хэмжээний тухай” А/139 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн эрүүл мэндийн салбарын хүрээнд 2020 оныг Сувилагч, эх баригчийн жил болгон зарлах, Олон улсын сувилагчдын өдрийг "Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг" сэдвийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Сувилахуй, Эх барихуйн тусламж үйлчилгээний чиглэлээр 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, "Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг" арга хэмжээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийг, хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү арга хэмжээг Аймгийн хэмжээнд зохион байгуулах, удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж, ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Оюунтуяа), Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Ю.Ичинноров) нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
03 дугаар сарын 20 өдрийн А/11
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# СУВИЛАХУЙ, ЭХ БАРИХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2020-03-16 Арвайхээр.

| № | ЭМЯ- наас хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл | Аймагт хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Хариуцан зохион байгуулах | | Хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ЭМГ | Байгууллагуудын хэмжээнд | |
| *Үйл ажиллагааны чиглэл-1* | | | *СУВИЛАХУЙ, ЭХ БАРИХУЙН АСУУДЛААРХ УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР* | | | |
| 1 | “1:2” зорилтот арга хэмжээний хүрээнд “Сувилагчийн мэдлэг, чадварыг бататгах”, “мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бэлтгэх” сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах | 1.1.Сувилагчийн мэдлэг, чадварыг бататгах”, “мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад сувилагч нарыг хамруулах ажлыг зохион байгуулах | Шалгалтад хамрагдсан сувилагчийн тоогоор | УТХ | -хүний нөөцийн асуудал хариуцдаг мэргэжилтэн<br>-Ахлах сувилагч | 2,3-р улиралд |
| | | 1.2. Туслах сувилагч бэлтгэдэг сургуулиудтай гэрээ байгуулан ажиллаж, сургалт зохион байгуулах | Бэлтгэсэн туслах сувилагчийн тоо | УТХ | хүний нөөцийн асуудал хариуцдаг мэргэжилтэн | 3,4-р улиралд |
| 2 | Сувилагч эх баригчийн ажил мэргэжлийг олон нийтэд сурталчлах ТВ танилцуулгыг | 2.1. Сувилагч, эх баригчдын өдрийг угтан цахим болон ТВ талархал, алдаршуулах | Цахим болон ТВ талархал ирүүлсэн хүний тоогоор | УТХ<br>ЭТХ | -хүний нөөцийн асуудлыг | 3,4-р улиралд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх | нэвтрүүлгийг бэлтгэж олон нийтэд түгээх | Нэвтрүүлгийн цагаар | | хариуцдаг мэргэжилтэн, -НЭМА | |
| 3 | Сувилахуй, эх барихуйн мэргэжлээр төгсөгчидтэй уулзах | 3.1. 2020 оны 6 дугаар сард Дархан, УБ хотын анагаахын сургуулиудын сувилахуй, эх барихуйн мэргэжлээр төгсөгчидтэй уулзалт зохион байгуулах | 2 удаагийн уулзалт зохион байгуулсан байна. Уулзалтад хамрагдсан оюутны тоо | УТХ ЭТХ | Байгууллагын дарга нар | 4-5 –р сарууддад |
| | | 3.2. ЕБС-ын 10-11 дүгээр ангийн сурагчдадын дунд Эссэ бичлэгийн уралдаан зарлах | Өдөрлөгт хамрагдсан сурагчийн тоогоор | УТХ ЭТХ | -хүний нөөцийн асуудлыг хариуцдаг мэргэжилтэн, -Ахлах сувилагч нар | 4-5-р сарууддад |
| 4 | ЭМС, аймгийн Засаг даргатай байгуулах гэрээнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын сувилагчийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр заалт тусган, хамтран ажиллах | 4.1.ЭМГ-ын дарга сумдын Засаг дарга нартай байгуулах гэрээнд орон нутгийн гэрээт сувилагч нарыг бэлтгэх ажлыг тусган ажиллах | Орон нутгийн гэрээт суралцагчийн тоогоор | УТХ | Байгууллагын дарга нар | жилдээ |
| | *Үйл ажиллагааны чиглэл-2* | | *СУВИЛАХУЙ, ЭХ БАРИХУЙН АСУУДЛААРХ УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР* | | | |
| 1 | Төгсөлтийн өмнөх сургалт-аар бэлтгэх сувилахуй, эх барихуйн мэргэжилтний тоо, төрлийг тусламж үйлчилгээ -ний эрэлт хэрэгцээ болон сургалт эрхлэгч байгууллага ын хүчин чадалд нийцүүлэн дунд хугацаанд тодорхойлж, | 1.1.ЕБС–ын 10, 11 дүгээр ангийн сурагчдын дунд “ Сувилагч” мэргэжлийн нэр хүндийг өргөсөн өдөрлөг, яриа, ухуулга зохион байгуулах | Өдөрлөгт оролцож, мэдээлэл авсан ахлах ангийн сурагчдын тоогоор Сувилагчийн мэргэжлийг сонгох хандлагатай сурагчдын тоогоор | УТХ ЭТХ | Байгууллагын дарга нар | 4-р сард |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | элсэлтэд баримтлах | 1.2.Сувилагч, эх баригчдын мэргэжлийг сурталчилах кино, зохиомжийг шалгаруулж, урамшуулах | Удирдамж, шалгаруулалтын дүн | ЭТХ | | 5-р сард |
| 2 | Нэн шаардлагатай мэргэшлээр сувилагчийг шат дараатайгаар бэлтгэх | 2.1. Нэн шаардлагатай мэргэшлээр сувилагч бэлтгэх судалгаа гаргах | Судалгааны үр дүн | УТХ<br>ЭТХ | -Сувилахуйн албаны дарга,<br>-Ахлах сувилагч нар | 3-р сард |
| 3 | Сувилагч мэргэжлээр суралцах оюутны сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх | 3.1. Сувилагч мэргэжлээр суралцах оюутны сургалтын зардлыг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүл<br>-эх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх | Зардлыг нь шийдвэрлэсэн оюутны тоогоор | УТХ | Байгууллагын дарга нар | жилдээ |
| | *Үйл ажиллагааны чиглэл 3.* | | *СУВИЛАХУЙ, ЭХ БАРИХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР* | | | |
| 3.1 | *"Nurseng-now" аяны нэгдүгээр зорилтын хүрээнд:*<br>*ДЭМБ –ЫН БҮР НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОРУУЛАХ ҮҮРГИЙГ ТОДОРХОЙ БОЛГОХ* | | | | | |
| 1 | "Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг" сэдвийн хүрээнд тэмдэглэх | 1.1.Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг" сэдвийн хүрээнд удирдамж гарган, зохион байгуулах | -Сувилагч эх баригчдын үйл ажиллагааг сурталчилах хүрээнд тэмдэглэсэн байна.<br>-Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | ЭТХ | -хүний нөөцийн асуудлыг хариуцдаг мэргэжилтэн | 2-р улиралд |
| 2 | Сувилахуйн асуудлаар баримтлах чиглэл, төлөвлөгөө боловсруулах | 2.1.Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөтөлбөрт, сувилахуй, эх баригчийн чиглэлээр тусгасан бодлогын заалтуудыг хэрэгжүүлж ажиллах | Заалтуудын хэрэгжилтийн хувь | УТХ<br>ЭТХ | Байгууллагын дарга нар | жилдээ |
| | | 2.2.Өвөрхангай аймгийн | Төлөвлөгөөний | УТХ | Ахлах | жилдээ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр 2018-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | хэрэгжилтийн хувь | ЭТХ | сувилагч | |
| 3 | Сувилахуйн төвийн олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагааны жишиг загвар, удирдамж, зөвлөмж боловсруулах | 3.1. Хархорин суманд “Сувилахуйн жишиг алба” зохион байгуулах төсөл хэрэгжүүлэх | Төсөл хэрэгжүүлж эхэлсэн байна | ЭТХ | Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн сувилахуйн алба | 2.3-р улиралд |
| 4 | Сувилахуйн асуудлаар донор орны тусламжтай “Сувилахуйн хөгжил” дэд хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх | 4.1.Сувилахуйн ухаанаар гадаад дотоодод магистр, докторын сургалтад хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх | Сувилахуйн магистрын тоо Докторантын тоо | ЭТХ УТХ | Сувилагч нар | жилдээ |
| | | 4.2. Сувилагч нарыг олон улсын хурал, сургалтад хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх | Гадаадын хурал, сургалтанд хамрагдсан сувилагчдын тоо | УТХ | Байгууллагын дарга нар | жилдээ |
| 5 | НЭМ-ийн сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх | Архаг, урт хугацаанд асаргаа, сувилгаа шаардлагатай үйлчлүүлэгч, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Сувилахуй - Сэргээн засах төв” байгуулах ажлыг бусад өмчийн хэлбэрийн байгууллагуудтай хэлэлцэн үйл ажиллагааг эхлүүлэх боломжийг судлах | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна. | ЭМГ, ЭТХ | Аймаг, сумын ЗДТГ, ИТХ, | Жилдээ |
| 3.2 | *“Nursing-now” аяны хоёрдугаар зорилтын хүрээнд:*<br>*СУВИЛАГЧДЫН ШИЙДВЭР ГАРГАХ, УДИРДЛАГА, МАНЛАЙЛЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ* | | | | | |
| 1 | Эрүүл мэндийн болон сургалтын мэргэжлийн | 1.1.Магадлан итгэмжлэлийн комиссын бүрэлдэхүүнд | Баталгаажсан эрх зүйн актаар | УТХ | - | 2-р улиралд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хяналт, магадлан итгэмжлэлийн бүх шатанд мэргэжлийн төлөөлөл ажиллуулах санал боловсруулах | сувилахуйн мэргэжилтнийг оруулах | | | | |
| 2 | ЭМХТ- ийн бүтцэд сувилахуй, эх барихуйн асуудал хариуцсан нэгж бий болгож, дараахь асуудлуудыг хариуцуулах | 2.1.Аймгийн тусгай зөвшөөрлийн комисс болон ерөнхий мэргэжилтний салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд сувилагч мэргэжилтний төлөөллийг оролцуулах | Баталгаажсан эрх зүйн актаар | УТХ | - | 2-р улиралд |
| | | 2.2. ЭМБ-ын эх баригч, сувилагчийн постыг байгууллагын дотоод сүлжээнд холбогдсон компьютераар шат дараатайгаар хангах, сувилагчийн хөтөлдөг бүртгэл, хяналтын маягтуудыг цахимжуулах | Эх баригч, сувилагчийн постыг компьютераар хангаж сүлжээнд холбогдсон байгууллагын тоо | ЭТХ ЗСНҮА | Байгууллагын дарга нар | жилдээ |
| 3.Сувилахуй, эх барихуйн удирдах түвшинд ажиллаж буй мэргэжилтнүүдийг удирдлага, манлайллын болон мэргэжлийн ахисан шатны сургалтад хамруулах | | 3.1. Удирдлагын академийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах | Удирдлагын академийн сургалтад хамруулсан сувилагчийн тоо | УТХ | - | 3-р улиралд |
| | | 3.2.Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг дээд шатлалын байгууллагуудад туршлага судлуулах | Туршлага судалсан мэргэжилтнүүдийн тоо | ЭТХ | Байгууллагын дарга нар | Жилдээ |
| 3.3 | *“ Nursing-now” аяны гуравдугаар зорилтын хүрээнд:*<br>*ҮР ДҮНТЭЙ ТУРШЛАГЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ* | | | | | |
| 1 | Үндэсний лавлагаа төв нь улсын хэмжээнд сувилахуйн мэргэжилт, арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээндээ | 1.1.Сувилагч, эх баригчдын аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулах | Зөвлөгөөнд оролцогчдын тоо, Шийдвэрлэсэн асуудлын тоогоор | УТХ ЭТХ | - | 2-р улиралд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дараах ажлыг тусган хэрэгжүүлэх | 1.2.Шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх бүртгэх, түгээх | Шинэ технологийн тоогоор | ЭТХ<br>УТХ<br>ЗСНҮА<br>ХШҮМХ<br>НЭМХ | Байгууллагын дарга нар | Жилийн турш |
| 2 | Өндөр өртөгтэй мэс засал, шинэ технологи бүхий тусламж, үйлчилгээг үзүүлэх багт ажилласан сувилагчийг багийн нийт бүрэлдэхүүний нэгэн адил урамшуулалд хамруулах тогтолцоог бүрдүүлж ажиллах | 2.1.Онц хүнд нөхцөлд хүний амь аварсан, нэн дутагдалтай нэгжид томилогдон ажилласан, шинэ технологи бүхий тусламж, үйлчилгээг үзүүлэх багт ажилласан сувилагчийг багийн нийт бүрэлдэхүүний нэгэн адил урамшуулалд хамруулах | Өндөр өртөгтэй мэс засал, шинэ технологи бүхий тусламж, үйлчилгээг үзүүлэх багт ажилласан урамшуулсан сувилагчийн тоо | ЭТХ<br>УТХ<br>ЗСНҮА | Байгууллагын дарга нар | Жилийн турш |
| 3 | Сувилахуйн судалгааны тэргүүлэх чиглэлд заасан сэдвээр сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжин хөгжүүлэх, урамшуулах, сурталчилах | 3.1. Сувилахуйн судалгааны тэргүүлэх чиглэлд заасан сэдвээр сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн дунд онол практикийн хурал зохион байгуулах | Судалгааны ажлын тоо,<br>Практик ач холбогдлын цар хүрээ | ЭТХ<br>УТХ<br>ХШҮМХ<br>НЭМХ | Байгууллагын дарга нар | Жилийн турш |
| | *“Nursing-now” аяны дөрөвдүгээр зорилтын хүрээнд:*<br>*НӨЛӨӨЛЛИЙН НОТЛОХ БАРИМТЫГ ҮҮСГЭХ ТҮГЭЭХ* | | | | | |
| 1. | Төрийн дээд шагналтан сувилагч, гавьяат сувилагч төрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | 1.1.Төрийн дээд шагналд сувилагч, эх баригч нарыг хэлэлцэн, материалыг хүргүүлэх | Урамшуулалд хамрагдсан сувилагчдын тоо | УТХ | Байгууллагын дарга нар | Жилийн турш |
| 2. | Сувилахуй, эх барихуйн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах, олон талт арга хэмжээг дэмжих, хяналт үнэлгээг тогтмолжуулах | 2.1. Сувилахуй, эх барихуйн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн ёс зүй, харилцааны соёлыг сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулах | Сувилахуй, эх барихуйн тусламж үйлчилгээтэй гомдол буурсан байна. | УТХ<br>ЭТХ | Ахлах сувилагч нар | Жилийн турш |
| 3.5 | *“Nursing-now” аяны дөрөвдүгээр зорилтын хүрээнд:*<br>*ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ /АЖЛЫН АЧААЛАЛ, НИЙГМИЙН АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ/* | | | | | |
| 1. | Сувилагч, эх баригчдын | 1.1.Сувилагч, эх баригчдын | Батлагдсан АБТ -ыг | УТХ | Ахлах | Жилдээ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, асрагч, сувилагчийн туслахын ажлын байрыг нэмэгдүүлж, сувилагчийн ачааллыг багасгах, тэнцвэржүүлэх зохицуулалтыг хийх / | ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахад саналаа хүргүүлэх | мөрдөж ажилласан байна. | ЭТХ | сувилагч нар | |
| | | 1.2.ЭМС-ын А/216 тушаал эх баригчийн ажлын байрны тодорхойлолтын хэрэгжилтийг сайжруулах | Батлагдсан АБТ -ыг мөрдөж ажилласан байна. | УТХ | Эх баригч нар | Жилийн турш |
| | | 1.3. Туслах сувилгчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах санал хүргүүлэх | Батлагдсан АБТ -ыг мөрдөж ажилласан байна. | УТХ | Сувилагч нар | Жилийн турш |
| 2. | Цалинг цагаар, боловсролын шатлалаар тооцох системд шилжүүлэх, ажлын цагийн уян хатан тогтолцоог нэвтрүүлэх боломжийг салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулан судалж, санал боловсруулах | Цалинг цагаар, боловсролын шатлалаар тооцох системд шилжүүл́эх, ажлын цагийн уян хатан тогтолцоог нэвтрүүлэхэд санал боловсруулж уламжлах | Саналын тоогоор | УТХ<br>ЭТХ | Сувилагч, эх баригч нар | 2-р улиралд |
| 3. | Сувилахуйн албадын үйл ажиллагааг чадавхижуулж, шинэ шатанд гаргах: | 3.1.Албадыг бүрэн бүтэц бүрэлдэхүүнээр нь ажиллуулах | Албадын бүтцийн хүний нөөцийн хувь | УТХ | Байгууллагын дарга нар | 2-р улиралд |
| | | 3.2.Албадын даргын сувилахуйн чанар сайжруулах асуудлаар шийдвэр гаргах /сувилахуйн санхүү, хүний нөөц, тоног төхөөрөмжийн хуваариалалт, захиалга сургалт/ эрх, мэдлийг | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор | УТХ | Байгууллагын дарга нар | Жилдээ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх | | | | |
| | | 3.3.Сувиахуйн удирдлагуудыг удирдлагын сургалтанд бүрэн хамруулах | Удирдлагын сургалтад хамрагдсан албадын дарга нарын эзлэх хувь, тоо | УТХ | Байгууллагын дарга нар | 2, 3-р улиралд |
| | | 3.4. Сувиахуйн удирдлагуудыг гадаадад танилцах аялалд бүрэн хамруулах | Хамрагдсан албадын дарга нарын тоо | УТХ | Байгууллагын дарга нар | Жилдээ |
| | | 3.5. Сувиахуйн удирдлагуудыг англи хэлний сургалтанд хамруулах асуудлыг байгууллагын дарга нартай зөвшилцөн шийдвэрлүүлэх | Хамрагдсан албадын дарга нарын тоо | УТХ | Байгууллагын дарга нар | Жилдээ |
| | | 3.6.Албадын дарга нарыг магистрын сургалтанд хамруулах асуудлыг байгууллагын дарга нартай зөвшилцөн шийдвэрлүүлэх | Хамрагдсан албадын дарга нарын тоо | УТХ | Байгууллагын дарга нар | Жилдээ |
| | | 3.7.Эрүүл мэндийн байгууллагуудын өвөрмөц нөхцөл байдалд тохирсон сувилагчийн ажлын ачааллын үнэлгээг хийж, үнэлэмжийг нэмэгдүүлэх дотоод зохион байгуулалтыг авч хэрэгжүүлэх | Хамрагдсан албадын дарга нарын тоо | УТХ | Байгууллагын дарга нар Ахлах сувилагч нар | Жилдээ |
| 4. | Нэг сувилагчид ногдох үйлчлүүлэгчийн тоог:<br>- Өрх, сум, тосгоны | 4.1.Нэг сувилагчид ногдох үйлчлүүлэгчийн тооны хязгаарыг тогтооход санал | Хэрэгжсэн саналын тоогоор | УТХ ЭТХ | Байгууллагын дарга нар Ахлах | 2-р улиралд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ЭМТ<br>- Нэгдсэн эмнэлэг<br>- Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн насанд хүрэгчид<br>- Хүүхдийн , хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн хэвтүүлэн эмчлэх нэг оронд ногдох байдлаар санал боловсруулж, хүний нөөцийн төлөвлөлтөнд тусган хэрэгжүүлэх | боловсруулан хүргүүлэх | | | сувилагч нар | |
| 5. | Сувилагч, эх баригчдын хөдөлмөрийн нөхцөл, ажиллах нөхцөл, аюулгүй байдалд үнэлгээ хийж, алын байранд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг дэмжих чиглэлээр: | 5.1.Ээлжийн сувилагч, эх баригчдын ажлын цагийг хорогдуулахасуудлыг судлан, зохистой хуваарилалт бүхий жишиг загвар боловсруулах | Ээлжийн сувилагч, эх баригчдын ажлын цагийг хорогдуулахасуудлыг судлан, санал боловсруулж уламжлах | ЭТХ | Ахлах сувилагч нар | 2-р улиралд |
| | | 5.2."Ээлжийн сувилагч, эх баригчдын эрүүл, аюулгүй хоол" аяныг ЭМБ-ын дунд хэрэгжүүлэх | Аяны удирдамж, шийдвэрлэсэн арга хэмжээний тоо | УТХ<br>ЭТХ | Ахлах сувилагч нар | 2-р улиралд |
| | | 5.3.Сувилахуйн, эх барихуйн тусламж үйлчилгээний нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт гаргах, хангах | Тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн тоо, санхүүжилтийн хэмжээгээр | ЭТХ<br>ЗСНҮА | Байгууллагын дарга нар, Ахлах сувилагч нар | 2,3-р улиралд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 5.4.Сувилагч, эх баригчдын эрүүл мэнд, нийгмийн байдлыг дэмжих, өвчлөлийн байдалд судалгаа хийж, эрүүлжүүлэх аян өрнүүлэх | Аяны удирдамж, үр дүнгийн тайлан мэдээ | УТХ ЭТХ | Байгууллагын дарга нар, Ахлах сувилагч нар | 2,3-р улиралд |
| | | 5.5.Амьдралын нөхцлийн судалгаа гаргаж, гэр, орон сууцгүй сувилагчдын судалгааг гаргаж, хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах, шийдвэрлэх зарим арга хэмжээг авч ажиллах | шийдвэрлэсэн арга хэмжээний тоо | УТХ ЭТХ | Байгууллагын дарга нар, Ахлах сувилагч нар | 2,3-р улиралд |
| | | 5.6.Цалингийн зээлтэй сувилагч, эх баригчдын судалгаа гаргаж, зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлэх асуудлыг арилжааны банкуудад хүргүүлж, шийдвэрлүүлж ажиллах | Цалингийн зээлтэй сувилагч, эх баригчдын судалгаа гаргах | УТХ, ЭТХ | хүний нөөцийн мэргэжилтнүүд санхүүгийн ажилтан | 2-р улиралд |
| | | 5.7. Сувилагч, эх баригчдыг орон сууцны хөнгөлөлтөд хамруулах, хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлан, асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах | шийдвэрлэсэн арга хэмжээний тоо | УТХ, ЭТХ | Байгууллагын дарга нар, -хүний нөөцийн асуудлыг хариуцдаг мэргэжилтэн | 2,3-р улиралд |
| | | 5.8. Сувилагч, эх баригчидад хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчилгээ үзүүлэх амралт, сувиллыг бий болгох асуудлаар аж ахуйн нэгж, ТББ-уудтай уулзалт зохион байгуулж, боломжийг судлах | Сувилагч, эх баригчид хөнгөлөлтэй нөхцлөөр үйлчилгээ үзүүлэх амраах асуудлаар аж ахуйн нэгжүүдтэй | УТХ ЭТХ | Байгууллагын дарга нар, -хүний нөөцийн асуудлыг хариуцдаг мэргэжилтэн | 2,3-р улиралд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | уулзалт зохион байгуулж, шийдвэрлэх | | | |
| 6 | Сувилагчийн хүний нөөцийг стандартын түвшинд хүргэн нэмэгдүүлж, зардлыг төсөвт нэмж суулгах | 6.1.Сувилагчийн хүний нөөцийг шат дараатайгар нэмэгдүүлэн, стандартын түвшинд хүргэх | Шинээр нэмэгдсэн сувилагчийн тоо | УТХ ЭТХ | Байгууллагын дарга нар, -хүний нөөцийн асуудлыг хариуцдаг мэргэжилтэн | Жилдээ |
| | | 6.2.Хүүхдийн сувилагч, эрчимт эмчилгээний сувилагч, нийгмийн эрүүл мэндийн сувилагчийг бэлтгэх | Шинээр нэмэгдсэн сувилагчийн тоо | УТХ ЭТХ | Байгууллагын дарга нар, -хүний нөөцийн асуудлыг хариуцдаг мэргэжилтэн | Жилдээ |
| **3.6. СУВИЛАХУЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ АСУУДЛААР** | | | | | | |
| 1. | Сувилагч, эх баригчдад төгсөлтийн дараах сургалтанд хамруулах мэргэжил, ур чадварыг тасралтгүй нэмэгдүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг хийх | Сувилагч, эх баригчдыг төгсөлтийн дараах сургалтанд хамруулж, мэргэжил, ур чадварыг тасралтгүй нэмэгдүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | Сургалтын тоо, хамрагдагсдын тоо | УТХ ЭТХ НЭМХ | Байгууллагын дарга нар, -хүний нөөцийн асуудлыг хариуцдаг Мэргэжилтэн -Ахлах сувилагч | Жилдээ |
| 2. | Сувилагч, эх баригчдыг төгсөлтийн дараах сургалтанд хамруулах төрийн сангийн дэмжлэгийг нэмэгдүүлэх | Сувилагч, эх баригчдыг төгсөлтийн дараах сургалтанд төрийн сангийн зардлаар сургах | Сургалтад хамрагдсан сувилагчийн тоо | УТХ | Байгууллагын дарга нар, -хүний нөөцийн асуудлыг хариуцдаг Мэргэжилтэн | Жилдээ |
| 3. | Эх барихын яаралтай тусламж, нярайн зүрх уушигны амилуулах | Эх барихын яаралтай тусламж, нярайн зүрх уушигны амилуулах | Сургалтад хамрагдсан эх баригчийн тоо | УТХ, ЭТХ | Байгууллагын дарга нар, -хүний | Жилдээ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тусламжаар “Эх баригч-Сургагч багш” бэлтгэх сургалт зохион байгуулах | тусламжаар “Эх баригч-Сургагч багш” бэлтгэх сургалтанд хамруулах | | | нөөцийн асуудлыг хариуцдаг мэргэжилтэн | |

-оОо-

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 20 өдрийн А/11 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

"БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТАД СУВИЛАГЧ, ЭХ БАРИГЧИЙН ҮҮРЭГ" АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН УДИРДАМЖ

**Зорилго:**

1. Сувилагч, эх баригчийн мэргэжлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, дэмжих, нэр хүндийг өргөх, сайн үйлсийг түгээн дэлгэрүүлэх
2. **Зорилт:**
   1. Нийгмийн тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллах
   2. Сувилагч, эх баригчийн мэргэжлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах
   3. Сувилагч, эх баригчдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжин хөгжүүлэх, урамшуулах, сурталчлах
   4. "Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг" сэдэвт өдөрлөгийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын түвшинд зохион байгуулах.
3. **Зохион байгуулагч:** Өвөрхангай аймаг Эрүүл мэндийн газар
4. **Хугацаа:** 2020 оны 03 сарын 18-наас 2020 оны 05 сар 01-ний хооронд зохион байгуулна.
5. **Хамрах хүрээ:** БОЭТ, нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллууд хамрагдана.
6. **Үр дүн:** Сувилагч, эх баригчийн мэргэжлийн үйл ажиллагааг олон нийтэд таниулж, сурталчлан, судалгаа шинжилгээний ажлыг дэмжин хөгжүүлж, нийгмийн тулгамдсан асуудал шийдвэрлэгдсэн байна.

1. ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ:

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах хэлтэс, албан тушаалтан | Хамтарч ажиллах байгууллага | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|
| **1.** | **Нийгмийн тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллах** | | | | |
| 1.1 | Сумын Засаг дарга, ЭМБ-ын дарга, удирдлага, сувилагчдын төлөөлөлтэй цахим уулзалт хийх | 4 сар | ЭТХ, УТСХ НЭМХ, ХШҮМХ | Аймаг, сумдын засаг дарга, ЭМБ-ын дарга, удирдлагууд, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн төлөөлөл | Гарсан саналын шийдвэрлэлт, бодит үр дүн |
| **2.** | **Сувилагч, эх баригчийн мэргэжлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах** | | | | |
| 2.1 | Сувилагч, эх баригчдын мэргэжлийг сурталчлах кино, зохиомжийг шалгаруулж,урамшуулах | 4 сар | ЭТХ, УТСХ НЭМХ, ХШҮМХ | Аймаг, сумын засаг дарга,<br>ЭМБ-ууд,<br>Орон нутгийн телевизүүд | Батлагдсан удирдамж, видео тайлан |
| 2.2 | Сувилагч, эх баригчийн амжилт бүтээлийг олон нийтэд төрөл бүрийн хэлбэрээр сурталчилж, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулах | 3-4 сар | ЭТХ, УТСХ НЭМХ, ХШҮМХ | ЭМБ-ууд<br>Орон нутгийн радио, телевиз | Радио, телевизээр явуулсан нэвтрүүлэг, бичлэг, мэдээ мэдээллийн тоо, төрөл давтамж, сонин сэтгүүлд хэвлүүлсэн бол эх хувь |
| 2.3 | Политехникийн коллежийн оюутнууд, Ерөнхий боловсролын 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Сувилагч, эх барихуйн мэргэжил миний бахархал” эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулах | 3-4 сар | ЭТХ, УТСХ НЭМХ, ХШҮМХ | ЭМБ-ууд, Ерөнхий боловсролын сургууль, Политехникийн коллеж, | Батлагдсан удирдамж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **3.** | **Сувилагч, эх баригчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжин хөгжүүлэх, урамшуулах, сурталчлах** | | | | |
| 3.1 | Сувилахуйн судалгааны тэргүүлэх чиглэлд заасан сэдвээр онол практикийн бага хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах | 4 сард | ЭТХ, УТСХ, НЭМХ, ХШҮМХ | ЗДТГ, ЭМБ-ууд | Батлагдсан удирдамж, бичмэл болон видео тайлан тайлан |
| **4.** | **"Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг" сэдэвт өдөрлөгийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын түвшинд зохион байгуулах.** | | | | |
| 4.1 | “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад сувилагч, эх баригчийн үүрэг” өдөрлөгийг байгуулага бүр зохион байгуулж сувилагч, эх баригчдын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах | 4 сард | ЭМБ-ууд | Аймаг, сумын засаг дарга,<br>Орон нутгийн телевизүүд | Зохион байгуулсан үйл ажиллагаа тус бүрийн удирдамж, хөтөлбөр, зурагжуулсан бичмэл болон видео тайлан |
| 4.2 | Сувилагч, эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн Нэгдсэн өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах | 4 сард | ЭМГ, ЗДТГ, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг | ЭМБ-ын дарга, удирдлагууд, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн төлөөлөл | Батлагдсан удирдамж, хөтөлбөр Нээлттэй өдөрлөгийн зурагжуулсан бичмэл тайлан |

-oOo-